**МОНГОЛ УЛСЫН**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ**
**САЙДЫН ТУШААЛ**

2004 оны 5 сарын 3 өдөр Дугаар 144 Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2004-2005 оны хичээлийн жилээс Япон Улсын Засгийн Газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй "Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэг" төслийн хүрээнд Японы их сургуулийн магистрантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан комиссын дүгнэлт, төслийн удирдах зөвлөлийн 2004 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дайрий овогтой Амаржаргалыг 2004-2005 оны хичээлийн жилээс "Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэг" төслийн хүрээнд Япон улсын Кобэгийн Их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т, суралцагчтай гэрээ байгуулахыг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны 49 дүгээр тушаалын Буянтогтох овогтой Нямаатай холбоотой хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

149 тушаалд кодификаци хийсэн

САЙД А.ЦАНЖИД

0000420